



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих жил болгон
зарлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.27, 2.1.1.28-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд 2025 оныг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласугай.

2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”-ийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газар (Ж.Энхтөр)-д зөвшөөрсүгэй.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг хагас жил, жилээр танилцуулж байхыг Хөдөлмөрийн бодлогын газар (Д.Ренчиндорж), Гэр бүлийн бодлогын газар (М.Цогтбаатар)-т тус тус даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул)-т үүрэг болгосугай.



D: 2025 on 02 sar tushaal

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдын 2025 оны 02 сарын
20-ны өдрийн тушаалын хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хөгжүүлж, нээлттэй зах зээлд ажиллах ур чадварыг олгон, тохируулгатай, хүртээмжтэй ажлын байрыг нэмэгдүүлэх замаар тэдний амьдралын чанарыг сайжруулна.

№	Гүйцэтгэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Төсөв (сая төг)	Эх үүсвэр	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хариуцах нэгж, байгуул- лага	Хамтран ажиллах
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд							
1.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн нээлтийг зохион байгуулах	I улиралд	10.0	ГБХНХЯ		ГББГ ХБГ	ХБХХЕГ ХБИХЭДТ
2.	Жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулах	Байнга	-	ГБХНХЯ	Үйл ажиллагааны тайлан	ХБХХЕГ ХБИХЭДТ	ГББГ ХБГ
3.	Жилийн ажлын явцыг хэлэлцэх уулзалтыг зохион байгуулах /орон нутгийн оролцоог цахим хэлбэрээр хангана/	Сар бүр	-	ХБХХЕГ		ХБХХЕГ ХБИХЭДТ	ГББГ ХБГ
4.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн ажлын үр дүнг хэлэлцэх Үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулах	III улиралд	200.0	ГБХНХЯ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-90	ГББГ ХБГ	ХБХХЕГ ХХҮЕГ ХБИХЭДТ
Нийт дүн			210.0				
Хоёр. Бодлого, эрх зүйн хүрээнд							
5.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах санал боловсруулах	I-IV улиралд	50.0	ГБХНХЯ	ЗГ-аар хэлэлцүүлсэн хууль-2	ХБГ ХХҮЕГ	ГББГ ХБХХЕГ
6.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний зураглалыг боловсруулж, танилцуулах	II улиралд	20.0	ГБХНХЯ	Зураглалын төсөл-2	ГББГ ХБХХЕГ	ХБГ ХХҮЕГ
7.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих стратеги боловсруулж, хэлэлцүүлэх	I-IV улиралд	20.0	ХБХХЕГ	Хөтөлбөрийн төсөл-1	ХБХХЕГ ХБИХЭДТ	ГББГ ХБГ ХХҮЕГ

8.	Хөдөлмөр эрхлэлтийн холбогдох журамд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээг тусгах асуудлаар санал боловсруулах	III улиралд	15.0	ХБХХЕГ	Журмын төсөл-2	ХБХХЕГ ХБИХЭДТ	ХБГ ХХҮЕГ
9.	Ажлын байрны хүртээмжийг сайжруулах асуудлаар ажил олгогчдод зориулсан зөвлөмж боловсруулах	II улиралд	5.0	ХБИХЭДТ	Зөвлөмж-1	ХБИХЭДТ	ГББГ
10.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж байгаа ажил олгогчдыг урамшуулах, дэмжихэд чиглэсэн бодлогын санал боловсруулж, хэлэлцүүлэх	II улиралд	5.0	ХБХХЕГ	Санал -1	ХБХХЕГ ХХҮЕГ ХБИХЭДТ	ХБГ ГББГ
11.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх, зарим үйлчилгээний зардалд норм норматив боловсруулж, бүтэц, орон тоог оновчтой болгох замаар төвүүдийн үйл ажиллагааны санхүүжилтийг боловсронгуй болгох	II-IV улиралд	5.0	ГБХНХЯ	Үйл ажиллагаа -1	ГББГ ЭЗСТХОГ	ХБХХЕГ
Нийт дүн			120.0				
Гурав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг эрчимжүүлэх хүрээнд							
12.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн зах зээл дээр ажиллуулах дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээг зохион байгуулах	I-IV улиралд	2422.9	ХЭДС	Хамрагдсан хүний тоо-300	ХБИХЭДТ	ХБХХЕГ
13.	Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй ажлын байр бий болгох болзолт уралдааныг зохион байгуулах	III улиралд	200.0	ГБХНХЯ	Хүртээмжтэй ажлын байр-ны тоо-100	ХБИХЭДТ	ГБХНХЯ
14.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийг сэргээн засах тусламж үйлчилгээгээр хангах, шинэ ажил мэргэжлийн чадвар олгох хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулан ажлын байранд зуучлах	II-IV улиралд	284.0	ХЭДС	Хамрагдсан иргэн-20	ХБХХЕГ	ХБИХЭДТ МБУЧОС ХАБЭМТ
15.	Ажлын байрны дадлагажуулагчийг бэлтгэх, үйлчилгээ үзүүлэх	I-IV улиралд	400.0	ХЭДС	Хамрагдсан иргэн-150	ХБХХЕГ	ХБИХЭДТ
16.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалагчийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих “Дэмнээ” аппликэйшн хөгжүүлж, хэрэглэх	I-IV улиралд	60.0	ГБХНХЯ	Аппликэйшн 1	ХБХХЕГ ХБИХЭДТ	Ханд про ХХК
17.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагыг санхүүгийн дэмжлэгт хамруулах	I-II улиралд	6700.0	ХЭДС	Хамрагдсан иргэн-560 ААНБ-12	ХБХХЕГ ХХҮЕГ	-

18.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгуулсан гарааны бизнесийг бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулж, бойжуулах	I-IV улиралд	846.0	ХЭДС	Хамрагдсан бойжигч-60	ХБИХЭДТ	ХБХХЕГ
19.	Дэлхийн ур чадварын Абилимп олон улсын уралдааныг үндэсний хэмжээнд зохион байгуулах	III-IV улиралд	270.0	ХЭДС	Хамрагдсан хүний тоо-50	СЗСҮТ ХБИХЭДТ	ХБХХЕГ
20.	Ажил хайгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг карьер хөгжлийн сургалт, зөвлөгөөнд хамруулж, ажлын байранд зуучлах	I-IV улиралд	93.0	ХЭДС	Хамрагдсан хүний тоо-850	ХХҮЕГ	ХБХХЕГ
21.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн байдалд улсын үзлэг зохион байгуулах	II-III улиралд	200.0	ГБХНХЯ ХЭДС	Хамрагдсан ААНБ-ын тоо-500	ГБХНХЯ ХБХХЕГ ХХҮЕГ	ТББ
22.	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 22.9, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг зохион байгуулах	I-IV улиралд	-	-	Хэрэгжилтийн хувь	Салбарын бүх байгууллага	
23.	Хөдөлмөр эрхэлж буй сонсголын бэрхшээлтэй хүнд зайнаас зөвлөн туслах, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, duudlaga.mn үйлчилгээ үзүүлэх	I-IV улиралд	120.0	ХЭДС	Хамрагдсан хүний тоо	ХБХХЕГ	ХБИХЭДТ
Нийт дүн			11,595.9				
Дөрөв. Орон нутагт зохион байгуулах арга хэмжээ							
24.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй өдөрлөг "Ability expo"-г бүсчлэн зохион байгуулах						
	Архангай аймаг	4-р сар	40.0	ХЭДС ГБХНХЯ ХБХХЕГ ХБИХЭДТ	Хамрагдсан хүний тоо Аймаг тус бүрт 300 Улаанбаатарт 1000	ГБХНХЯ ХБХХЕГ ХБИХЭДТ СЗСҮТ	ЦИӨБГ Ханд про ХХК ТББ
	Дархан-Уул аймаг	5-р сар	40.0				
	Дорнод аймаг	9-р сар	40.0				
	Дундговь аймаг	10-р сар	40.0				
	Ховд аймаг	9-р сар	40.0				
	Хөвсгөл аймаг	6-р сар	45.0				
	Улаанбаатар хот	6-р сар	100.0				
25.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүсчилсэн чуулга, уулзалт зохион байгуулах	4-10-р сар	150.0	Аймаг, нийслэлийн Засаг дарга ГБХНХЯ	Хамрагдсан хүний тоо-1000	ГБХНХЯ ХБХХЕГ	Аймгийн ХБХХТ

26.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах салбар зөвлөлийн хурлыг бүсчлэн зохион байгуулж, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хэлэлцэх	4-10-р сар	100.0	Аймаг, нийслэлийн Засаг дарга ГБХНХЯ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо-6	ГБХНХЯ ХБХХЕГ ХХҮЕГ	ТББ-ууд
Нийт дүн			595.0				
Тав. Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ							
27.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй тохируулгатай орчин бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаар хамт олны ойлголт, хандлагыг өөрчлөх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	I-IV улиралд	100.0	Аймаг, нийслэлийн Засаг дарга, ААНБ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	ХБХХЕГ ТББ	ХБИХЭДТ
28.	ААНБ-уудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хууль эрх зүй, дүрэм журмын талаар нөлөөллийн сургалтыг зохион байгуулах, сурталчлан таниулах	I-IV улиралд	100.0	ХЭДС Аймаг, нийслэлийн Засаг дарга, ААНБ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	ХБХХЕГ ТББ	ХБИХЭДТ
29.	Хөдөлмөр эрхлэлтийн сайн жишээг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	I-IV улиралд	500.0	ХЭДС Аймаг, нийслэлийн Засаг дарга, ААНБ	Сурталчилгаа нөлөөллийн арга хэмжээний тоо-50	ГБХНХЯ ХБХХЕГ	ХБИХЭДТ
30.	Ажил хөдөлмөр эрхлэх ач холбогдлын талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	I-IV улиралд	250.0	ХЭДС Аймаг, нийслэлийн Засаг дарга, ААНБ	Сурталчилгаа нөлөөллийн арга хэмжээний тоо-30	ГБХНХЯ ХБХХЕГ	ХБИХЭДТ
31.	Аж ахуйн нэгж байгууллагуудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих өдөрлөгийг зохион байгуулах	Сар бүр	50.0	ХЭДС	Хамрагдсан байгууллага-100	ХБИХЭДТ	ХБХХЕГ СЗСҮТ
32.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах	II улиралд	50.0	ХЭДС	Хамрагдсан хүний тоо-50	ХБИХЭДТ	ХХҮЕГ

33.	Олны танил хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амжилтын түүхийг олон нийтэд хүргэж сурталчлах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	I-IV улиралд	100.0	ХЭДС	Зохион байгуулсан арга хэмжээ-ний тоо	ХБИХЭДТ	ХБХХЕГ ТББ
34.	Хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөр эрхлэхэд нь зориулж хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, хувийн туслах бэлтгэх сургалт зохион байгуулах, олон нийтэд түгээх	I-IV улиралд	740.0	ХЭДС	Хамрагдсан хүний тоо-100	ХБХХЕГ	ХБИХЭДТ
Нийт дүн			1,890				
Зургаа. Судалгаа, мэдээллийн арга хэмжээ							
35.	Улсын хэмжээнд хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэдийн судалгаа хийж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх стратеги боловсруулах	I-II Улиралд	700.0	ХЭДС	Судалгаанд хамрагдсан иргэн-5000	ХБИХЭДТ ХНХСҮСИ	ГБХНХЯ ХБХХЕГ ХХҮЕГ
36.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээ хийх арга зүйг боловсруулж, турших, хэрэгжүүлэх	I-II улиралд	105.0	ХЭДС	Хамрагдсан иргэний тоо 320	ХБИХЭДТ	ХБХХЕГ
37.	Хөдөлмөр эрхлэлтийн төвөөс үйлчилгээ авсан иргэдийн мэдээллийн сан бүрдүүлж, үйлчилгээний үр дүнг мөшгөх судалгаа хийх	I-IV улиралд	50.0	ХБИХЭДТ	Судалгаанд хамрагдсан иргэн-500	ХБИХЭДТ	ТББ
38.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сан байгуулж, холбогдох статистик маягтыг батлан хэрэгжүүлэх	I-IV улиралд	100.0	ГБХНХЯ ХБХХЕГ	Мэдээллийн сан-1 Маягт-10	ЦХИӨГ ХБХХЕГ	ГББГ ХБИХЭДТ
39.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан хөгжлийн бэрхшээлийн онцлог, хэрэгцээнд нийцэх ажлын байрны судалгаа хийх, түгээх	II-III улиралд	50,0	ХЭДС	Судалгааны тайлан-1	ХБИХЭДТ ХНХСҮСИ	ХБХХЕГ
40.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагын хэрэгцээг тодорхойлох судалгаа хийж, сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	I-III улиралд	50,0	АХБ ХБИОДҮС Т	Сургалтад хамрагдсан хүн-50	ХБИХЭДТ	ХБХХЕГ ТББ
41.	Хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч, хүний хөдөлмөр эрхлэлтийн судалгаа гаргах	II-III улиралд	5.0	ГБХНХЯ	Судалгаа-1	ГБХНХЯ НДХСБГ	НДЕГ, ЭММТЗ
42.	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн тайлан, танилцуулга хийх	IV улиралд	5.0	ГБХНХЯ	Тайлан-1	ГБХНХЯ НДХСБГ	НДЕГ, ЭММТЗ
Нийт дүн			1,065				
НИЙТ			15,475.9				

Үүнээс	14.035,9
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	
ГБХНХЯ-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн сангаас	885.0
ХБХХЕГ	170.0
Орон нутаг	350.0
ХБИХЭДТ	90.0
ADB хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжих үйлчилгээг сайжруулах төсөл	50.0

Хүрэх үр дүн

- Нийт 12,000 орчим хүнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүргэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй 2000 гаруй хүнийг ажлын байртай болгоно.
- Улсын хэмжээний хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн сантай болно.
- 500-аас багагүй аж ахуй нэгж байгууллагыг нөлөөллийн арга хэмжээнд хамруулна.